



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 497

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны "Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай" 175 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (хуучин нэрээр)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 24,869,856,814.74 (хорин дөрвөн тэрбум найман зуун жаран есөн сая найман зуун тавин зургаан мянга найман зуун авсан дөрвөн төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 20,469,692,524.79 (хорин тэрбум дөрвөн зуун жаран есөн сая зургаан зуун ерэн хоёр мянга таван зуун хорин дөрвөн төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 дүгээр хавсралтад заасан эд хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (хуучин нэрээр)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,233,677,040.74 (нэг тэрбум хоёр зуун гучин гурван сая зургаан зуун далан долоон мянга дөчин төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,038,107,454.17 (нэг тэрбум гучин найман сая нэг зуун долоон мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг авсан долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 дугаар хавсралтад заасан эд хөрөнгийг Оюуны өмчийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Оюуны өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

000237-